



ДУНДГОВЬ АЙМАГ
БАЯНЖАРГАЛАН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 08 сарын 04 өдөр

Дугаар А/45

Аргатай

Хонины цэцэг, Бруцеллэз өвчнөөс
урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын
ажлыг зохион байгуулах тухай


Монгол Улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4-9.8 дахь хэсэг, Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2023 оны 07 дугаар сарын 31-ний өдрийн А/178 дугаар тушаал, аймгийн Засаг даргын 2023 оны 07 дугаар сарын 27-ны өдрийн А/458 тоот захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Малчид, мал бүхий иргэдэд вакцинжуулалтын мэдээлэл хүргэн, хонь, хургыг дархлаажуулалтад бүрэн хамруулах арга хэмжээг Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын баталсан стандарт ажиллагааны дагуу 2023 оны 08-р сарын 03-ны өдрөөс 20 хоногийн хугацаанд зохион байгуулсугай.

2. Хонь, ямааны цэцэг болон бруцеллэз өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын арга хэмжээг чанартай зохион байгуулж, гүйцэтгэлийн баримт бичгийг цаг хугацаанд нь Мал эмнэлгийн тасагт хүлээлгэн өгөхийг Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн эмч нарт үүрэг болгосугай.

3. Дархлаажуулалтын арга хэмжээг малчин болон мал бүхий иргэдэд зарлан мэдээллэж, мал сүргийг бүрэн хамруулахыг багийн Засаг дарга нарт үүрэг даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮВ
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



482701087